

**БАГАНУУР ДҮҮРГИЙН ТӨР ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГА,
“БАГАНУУР” ХК-ИЙН ХООРОНДЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ
САНАМЖ БИЧИГ**

Нэг талаас Багануур дүүргийн Төр захиргааны байгууллага, нөгөө талаас “Багануур” Хувьцаат Компани (цаашид хамтад нь талууд гэх) хамтран ажиллах талаар тохиролцож энэхүү санамж бичгийг үйлдэв.

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Санамж бичгийн зорилго нь: Багануур дүүргийн төр захиргааны байгууллага болон “Багануур” ХК-ийн хамтын ажиллагааг сайжруулах, иргэдэд хүргэх, үйлчилгээний цар хүрээг өргөтгөж, нийтлэг эрх ашгийн төлөө хамтран ажиллахад оршино.
- 1.2 Талууд хамтын ажиллагаандаа Монгол улсын Үндсэн хууль болон холбогдох хууль тогтоомжийг удирдлага болгон харилцан бие биеэ хүндэтгэн, ил тод нээлттэй байх, үр дүнг нэгтгэн хэлэлцэх зарчмыг баримтална.

Хоёр.Төр захиргааны байгууллагаас хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл

- 2.1 Засгийн газар, Яам агентлаг, нийслэлийн түвшинд “Багануур” ХК-тай холбогдолтой асуудлыг уламжлан хамтран ажиллах.
- 2.2 “Багануур” ХК-ийн ажилтнуудыг төрийн дээд шагналаар шагнуулахад бодлогоор дэмжиж ажиллах.
- 2.3 Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар хэрэгжиж буй “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд 2030 он хүртэл “Багануур”ХК-ийн “Нэг сая мод” тарих аяны хэрэгжилтийг дэмжин мод бутны үрсэлгээ, бойжуулалт хийх 16 /арван зургаан/ га газрын асуудлыг орон нутгийн тусгай хэрэгцээний зориулалтаар шийдвэрлэх.
- 2.4 Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар хэрэгжиж буй “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн, “Багануур” ХК-ийн “Нэг сая мод” тарих ажлын хүрээнд 2025-2030 он хүртэл таригдах 358 000 ширхэг модны 120 га газрын асуудлыг шийдвэрлэх.
- 2.5 Багануур дүүргийн 45 жилийн ой, Багануур Хувьцаат компанийн 50 жилийн ойг угтаж Багануур Хувьцаат компанийн нэрэмжит Цэцэрлэгт хүрээлэн байгуулах газрын асуудлыг шийдвэрлэх.
- 2.6 Уурхайн олборлолт явагдаж байгаа талбай руу гадаргын ус орохоос урьдчилан сэргийлэх зорилгоор Хуцаагийн голын хуучин голдирлыг хааж шинээр далан хаалт байгуулахад дэмжлэг үзүүлэн, холбогдох зөвшөөрлийг зохих дүрэм журмын дагуу олгох.
- 2.7 Засгийн газрын 14 мега төслийн нэг, Эрдэнэс Монгол нэгдлийн стратеги төлөвлөгөөнд туссан Багануур ХК-ийг түшиглэн байгуулах Багануур УТП-ын “Хөх нүүрс” төсөлд дэмжлэг үзүүлж ажиллах.
- 2.8 2026 онд Монгол улсад зохион байгуулагдах Цөлжилтийн эсрэг НҮБ-ын конвенцын КОП-17 хурлын хүрээнд дээд түвшний уулзалт зохион байгуулагдахтай холбогдуулан дүүргийн хэмжээнд бэлтгэл ажлыг хангах.

Гурав. “Багануур” ХК-иас хэрэгжүүлэх үйл ажиллагааны үндсэн чиглэл

- 3.1 Үйлдвэрлэлийн үйл ажиллагаанаас үүсэж буй хог хаягдлыг ангилан ялгах, холбогдох байгууллагуудтай гэрээ байгуулж тушааж ажиллах.
- 3.2 Цэвэрлэгээ үйлчилгээг тогтмолжуулж, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх. (дүүргийн нутаг дэвсгэрийн хур хог хаягдлыг зайлуулахад машин техник, хүн хүчний дэмжлэг үзүүлэх, нийтийн эзэмшлийн зам талбайн цас цэвэрлэгээнд тогтмол оролцох).
- 3.3 Байгалийн болон нийтийг хамарсан гамшиг ослын үед өөрийн байгууллагын автомашин техник хэрэгслээр дэмжих.
- 3.4 Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн “Хот хөдөөгийн сэргэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 68 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Багануур ХК-д ажилд орж буй иргэн нь нэн шаардлагатай ажил мэргэжлээс бусад тохиолдолд Багануур дүүргийн иргэн байх.
- 3.5 Уурхайн олборлолт явагдаж байгаа талбай руу гадаргын ус орохоос урьдчилан сэргийлэх зорилгоор Хуцаагийн голын хуучин голдирлыг хааж шинээр далан хаалт байгуулах.
- 3.6 Дүүргийн иргэн, ААН байгууллагын ажилтнуудыг компанитай танилцах боломжоор хангах.
- 3.7 Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар хэрэгжиж буй “Тэрбум мод үндэсний хөдөлгөөн”-нд нэгдэж “Нэг сая мод тарих аян”-ыг өрнүүлж дүүрэгт 16,000 (арван зургаан мянга) мод тарих.
- 3.8 Дүүргийн аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд компанийн Байгаль орчин, нөхөн сэргээлт, “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд хэрэгжүүлж байгаа ажлыг танилцуулах, СӨБ, ЕБС-ийн сурагчдад хүрээлэн буй орчин, модны ач тус, мод тарих арга, хог хаягдлыг ангилж хаях талаар сургалт явуулах.
- 3.9 “Төмөр динозавр” музей, соёл амралтын хүрээлэн байгуулах төслийн хүрээнд хамтран ажиллах.
- 3.10 Нийтийг хамарсан олон нийтийн үйл ажиллагаанд хамтран ажиллаж, дэмжлэг үзүүлэх.
- 3.11 Дүүргийн амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой иргэдэд хөнгөлөлттэй үнээр нүүрс нийлүүлэх.

Дөрөв. Хамтран зохион байгуулах үйл ажиллагааны чиглэл:

- 4.1 Гудамжны шавар шавхайг багасгахын тулд өндөржилтийн цэгийг тогтооход хамтран ажиллах.
- 4.2 ИТХ-ын дарга, Засаг даргын зүгээс хагас жилд 1-2 удаа Багануур ХК-ийн ажилтнуудад холбогдох мэдээллийг хүргэж, уурхайчдын санал хүсэлтийг сонсдог байх. /Төрийн байгууллагууд уурхай дээр очиж төрийн үйлчилгээ үзүүлж, зөвлөмж өгдөг байх/
- 4.3 Хэвлэл мэдээллийн хамтын ажиллагааг бий болгох.
- 4.4 Дүүргийн Засаг даргын нэрэмжит “Хөдөлгөөн эрүүл мэнд” биеийн тамирын спортын их наадам болон “Шүд угаалт” тэмцээнийг зохион байгуулахад хамтарч ажиллах.
- 4.5 Багануур дүүрэг үүсэн байгуулагдсаны 45 жилийн ойн хүрээнд наадмын талбайн тохижилтын ажилд техникийн дэмжлэг үзүүлж хамтран ажиллах.
- 4.6 Ухсан эзэнгүй нүхийг дарж булахад тодорхой хэмжээнд техникийн дэмжлэг үзүүлэх.

- 4.7 Шинэ хогийн цэгийн өргөтгөлийг хийхэд тодорхой хэмжээнд техникийн дэмжлэг үзүүлэх.
- 4.8 Малчдад туслах аяныг зохион байгуулах.

Тав.Хамтын ажиллагаанд талуудын хүлээх үүрэг

- 5.1 Талууд хамтын ажиллагааг өргөжүүлэх, хоорондын уялдаа холбоог сайжруулах чиглэлээр гаргасан санал, санаачилгыг дэмжин ажиллах;
- 5.2 Талууд хамтын ажиллагааны явцад танилцсан мэдээллийг зөвхөн хууль тогтоомжид заасан үндэслэлээр ашиглах, бусдад задруулахгүй байх;
- 5.3 Талууд хамтран хэрэгжүүлэх ажлын нэгдсэн төлөвлөгөө гарган ажиллах;

Зургаа. Бусад зүйл

- 6.1 Энэхүү санамж бичиг нь талууд гарын үсэг зурж баталгаажсан өдрөөс хойш 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэлх хугацаанд мөрдөгдөнө.
- 6.2 Талууд харилцан тохиролцож санамж бичигт нэмэлт өөрчлөлт оруулан, албан тэмдэглэл үйлдэн хавсаргаж болно.
- 6.3 Санамж бичгийн хэрэгжилтийг бүтэн жилээр хэлэлцэж дүгнэнэ.
- 6.4 Санамж бичгийн биелэлтийг хангах явцад гарсан маргаан, зөрчлийг зөвшилцлийн аргаар шийдвэрлэнэ.

Энэхүү санамж бичгийг 2025 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр Багануур дүүрэгт хоёр эх хувь үйлдсэн бөгөөд эх бичвэрүүд адил хүчинтэй байна

САНАМЖ БИЧИГ БАЙГУУЛСАН:

БАГАНУУР ДҮҮРГИЙН ЗАСАГ
ДАРГА
С.ДАВААСҮРЭН
/гарын үсэг, тамга/

“БАГАНУУР” ХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРЛЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ
Д.ТАШИНЖАРГАЛ
/гарын үсэг, тамга/

